

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/03/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Чингис хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.08.25 № 407
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 508,032.4 мянган төгрөг, авлага 163,513.9 мянган төгрөг, урьдчилгаа 300.0 мянган төгрөг, бараа материал 212,626.7 мянган төгрөг, нөөцийн бараа 10,500.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,032,250.7 мянган төгрөг, өр төлбөр 1,837.7 мянган төгрөг, засгийн газрын сан 463,938.5 мянган төгрөг, хуримтлагдсан үр дүн 3,387,396.80 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 610,218.8 мянган төгрөг, сумын татварын ба татварын бус орлогоос 434,769.7 мянган төгрөгийг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээс 130,434.9 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 49,346.9 мянган төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос 432.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2024082508

Аудитын гол асуудал

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг хугацаанд мэдээлсэн төлөвт байгаа ч оруулах мэдээлэл байхгүй гэж 230.4 сая төгрөгийн 4 тендерийн мэдээллийг мэдээлээгүй орхигдуулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 223.5 сая төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 264.0 сая төгрөгийн 18 гүйлгээг огт мэдээлээгүй зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Сумын Засаг дарга нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэхгүй байгаа тул дараа жилийн аудитад анхаарах шаардлагатай.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаарахгүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Дансны код	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		708,569.42	894,972.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	380,996.82	508,032.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	187,338.63	163,513.86
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	300.00	300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	129,379.47	212,626.70
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	10,554.50	10,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,086,506.25	3,032,250.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,086,506.25	3,032,250.70
39200	Биет хөрөнгө		3,049,101.50	2,994,995.95
39300	Биет бус хөрөнгө		37,404.75	37,254.75
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,795,075.66	3,927,223.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,686.12	1,837.68
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,686.12	1,837.68
41300	Өглөг	17а, 17б	2,686.12	1,837.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,792,389.54	3,925,385.99
51	Засгийн газрын хувь оролцоо		3,792,389.54	3,925,385.99
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		463,938.49	463,938.49
51200	Хуримтлагдсан үр дүн		3,254,400.31	3,387,396.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		74,050.74	74,050.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,795,075.66	3,927,223.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,595,761.18	2,786,232.76
11	ТАТВАРЫН ОРЛОГО		293,093.77	423,882.71
110	Орлогын албан татвар		137,670.10	170,516.27
1100	Хувь хүний орлогын албан татвар		137,670.10	170,516.27
113	Хөрөнгийн албан татвар		98,043.50	79,998.84
118	Бусад татвар, төлбөр, хураамж		57,380.17	173,367.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,735,855.00	345,066.43
120	Нийтлэг татварын бус орлого		1,735,855.00	345,066.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,566,812.41	2,017,283.62
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,644,960.63	2,378,050.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,644,960.63	2,378,050.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		704,232.88	1,076,692.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		266,313.27	352,564.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		32,479.90	44,040.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		188,310.73	34,875.32
2104	Хангамж, бараа материалын зардал		37,963.58	49,315.56
2105	Нормативт зардал		3,000.00	4,462.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		22,119.22	14,126.80
2107	Томилолт, зочны зардал		3,211.00	16,879.25
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,027.51	234,040.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		131,807.67	326,386.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		940,727.75	1,301,358.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		1,950,800.55	408,182.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(3,815,777.61)	(274,683.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(1,864,977.06)	133,498.44

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгийн дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,673,532.91	-	5,673,532.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(16,166.31)	-	(16,166.31)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,657,366.60	-	5,657,366.60
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(1,864,977.06)	-	(1,864,977.06)
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,792,389.54	-	3,792,389.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(502.00)	-	(502.00)
D08	Тайлант үеийн үр дүн	133,498.44	-	133,498.44
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,925,385.99	-	3,925,385.99

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,955,825.04	2,505,601.71
11	ТАТВАРЫН ОРЛОГО	293,093.77	423,882.71
110	Орлогын албан татвар	137,670.10	170,516.27
1100	Хувь хүний орлогын албан татвар	137,670.10	170,516.27
113	Хөрөнгийн албан татвар	98,043.50	79,998.84
118	Бусад татвар, төлбөр, хураамж	57,380.17	173,367.61
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	21,475.14	28,601.98
1181	Газрын төлбөр	1,559.03	1,467.63
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,346.00	143,298.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,918.86	61,492.02
120	Нийтлэг татварын бус орлого	95,918.86	61,492.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,566,812.41	2,020,226.97
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,620,516.19	2,104,259.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,620,516.19	2,104,259.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,966.25	799,297.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,305.56	355,906.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,568.52	43,417.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,458.21	36,360.56
2104	Хангамж, бараа материалын зардал	37,372.22	43,494.63
2105	Нормативт зардал	6,600.00	1,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,852.19	12,527.70
2107	Томилолт, зочны зардал	3,211.00	15,294.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,030.09	244,971.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,568.45	46,325.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,004,549.94	1,304,961.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	335,308.86	401,342.18
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	205,999.38	274,306.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	205,999.38	274,306.60
2200	Дотоод эх үүсвэрээр	205,999.38	274,306.60
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(205,999.38)	(274,306.60)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	129,309.48	127,035.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	251,687.34	380,996.82
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	380,996.82	508,032.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,439,444.40	1,098,175.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,002,618.50	827,418.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	951,905.20	778,225.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,888.30	355,051.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,514.60	43,417.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,867.30	204,659.52
2104	Хангамж, бараа материалын зардал	42,324.50	40,685.29
2105	Нормативт зардал	488.60	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,557.90	25,495.05
2107	Томилолт, зочны зардал	18,670.80	15,294.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,131.60	58,797.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,461.60	34,825.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,713.30	49,193.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,713.30	49,193.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	302,408.90	270,756.60
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	134,417.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,439,444.40	1,082,266.40
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,211,251.40	1,031,661.38
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	240,389.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	224,480.15

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,465.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,465.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,622.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,809.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	854.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,603.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,843.58
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,465.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,465.80

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 246.5 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Замд яваа мөнгөн хөрөнгийг 246.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнагдсан.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг хугацаанд мэдээлсэн төлөвт байгаа ч оруулах мэдээлэл байхгүй гэж 230.4 сая төгрөгийн 4 тендерийн мэдээллийг мэдээлээгүй орхигдуулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 223.5 сая төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 264.0 сая төгрөгийн 18 гүйлгээг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэлт: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж ажиллах зөвлөмж өгсөн.

Тус Засаг даргын тайланд нэгтгэгддэг орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 25,995.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 22,257.5 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 3,738.3 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлэн ажилласан.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	300.0			1	300.0	1	300.0				
ОНХС	1	19,374.9			1	19,374.9	1	19,374.9				
ХХС	1	2,582.6			1	2,582.6	1	2,582.6				
Дүн	1	22,257.5			1	22,257.5	1	22,257.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	А/т	Тоо	Дүн
ЗДТГ	1	3,738.3					1	3,738.3						
Дүн	1	3,738.3					1	3,738.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Засаг дарга	1	717,940.1						1	717,940.1
Дүн	1	717,940.1	-	-	-	-	-	1	717,940.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Байхгүй									
Дүн	1	717,940.1						1	717,940.1
Нийт дүн	1	717,940.1	-	-	-	-	-	1	717,940.1